



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 12 өдөр

Дугаар А/158

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5, 4.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны ээлжит IX хуралдааны 05 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2022 оны 13 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сангийн яамнаас “Цахим гүйлгээ нэвтрүүлэх” сургалтыг Хөвсгөл аймагт зохион байгуулахад гарсан зардалд 536,000 (Таван зуун гучин зургаан мянга) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх зардлын 536,000 (Таван зуун гучин зургаан мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын тамгын газар (П.Ариунбат)-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН